



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 23 өдөр

дугаар A/495

Улаанбаатар хот

Үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний татварын албаны 2015 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай;
2. Үндсэн чиглэлд тодорхойлсон стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Татварын ерөнхий газрын дотоод бүтцийн болон харьяа нэгжийн дарга нарт үүрэг болгосугай;
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (С.Орхон), хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (С.Энхбат)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Б.АРИУНСАН

Татварын ерөнхий газрын даргын
2014 оны 12 сарын 23-ний өдрийн
A/495 дүгээр тушаалын хавсралт

УХА0019

ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН АЛБАНЫ 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

“Үндэсний татварын албаны 2015 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл”-ийн зорилго нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу 2015 онд татварын бодлогын хүрээнд тавигдсан зорилт, арга хэмжээнүүд болон “Үндэсний татварын албаны 2014-2016 оны хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2015 оны үйл ажиллагааны зорилт, стратегийг тодорхойлоход оршино.

Үндэсний татварын албаны хэмжэнд 2015 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, уг хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх Төсвийн тухай хуульд заасан чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг ханган биелүүлж ажиллана.

Үндэсний татварын алба 2015 оныг “**Бизнес эрхлэлтийг дэмжих жил**” болгон дараах зорилт, стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

ЗОРИЛТ 1. Орчин үеийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, бизнесийг дэмжсэн татварын хоёр дахь шатны шинэчлэлийг хийхэд оролцоно:

Стратеги 1. Татварын хоёр дахь шатны шинэчлэлийн хүрээнд татварын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор татварын хуулиудад шинэчилсэн найруулга хийх, нэмэлт, өөрчлөлт оруулах, болон шинээр бий болгох хуулийн төслүүдийг Монгол Улсын Сангийн яамтай хамтран боловсруулж, удирдах дээд байгууллагад шийдвэрлүүлэхээр хүргүүлнэ. Хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад холбогдох судалгаа, мэдээ, тайлбараар хангаж ажиллана;

Стратеги 2. Шинээр батлагдсан татварын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор нийтээр болон үндэсний татварын албаны хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, аргачлал, заавар, зөвлөмж, маягтын төслийг боловсруулж батлуулан мөрдүүлнэ;

Стратеги 3. Үнэ шилжилт, нимгэн капиталжуулалт, үндэстэн дамжсан компаний татвар, ашиг шилжүүлэх зэрэг олон улсын татварын болон татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх олон улсын арга зүйн талаар санал, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулж батлуулан мөрдүүлнэ;

Стратеги 4. Татварын хуулийг албаны хэмжээнд нэг мөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна;

ЗОРИЛТ 2. Татварын албаны үндсэн үйл ажиллагааны технологийг боловсронгуй болгон татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, далд эдийн засгийг бууруулан төсвийн татварын орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлнэ:

Стратеги 1. Татвар ногдуулах, хураах үйл ажиллагааны технологийг боловсронгуй болгох, ногдуулсан татварыг бүрэн хураах үр ашигтай арга хэлбэрийг нэвтрүүлж, төсөвт төвлөрүүлэх татварын орлогын хэмжээг нэмэгдүүлнэ;

Стратеги 2. Татварын өрийн удирдлагыг боловсронгуй болгон “Өр дуудах төв”-ийн үйл ажиллагааг эхлүүлж, татвар төлөгчийг хууль хэрэгжүүлэлтийн түвшингээр нь ангилах, ангилал бүрт тохирсон арга хэмжээ авах, өр барагдуулах чиглэлээр хууль хяналтын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагатай хамтран ажиллах ажиллагааг эрчимжүүлж, үр дүнг тооцож ажиллана;

Стратеги 3. Татвараас зайлсхийх үзэгдэлтэй тэмцэх, нуугдмал орлогыг ил болгох чиглэлээр эрсдэлд суурилсан татварын хяналт шалгалтын үйл ажиллагааг нэвтрүүлж, үр дүнг тооцон татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж нуугдмал орлогыг татварт хамруулах замаар төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нэмэгдүүлнэ;

Стратеги 4. Татварын албаны хөндлөнгийн мэдээлэл болон санхүү, татварын тайлангийн мэдээлэлд үндэслэн татвар төлөгчийн ирүүлсэн тайланд ногдуулалтын хяналт хийх ажиллагааг боловсронгуй болгон, татвар төлөгчийг эрсдэлээс хамгаалж, татварын хуулийн хэрэгжилтийг хангана;

Стратеги 5. Эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэл боловсруулах, статистик шинжилгээ хийх арга хэрэгслийг боловсронгуй болгон хөгжүүлж, татварын эрсдэлийн сангийн болон үндсэн үйл ажиллагааны статистик мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, мэдээлэл түгээх тогтолцоог боловсронгуй болгож, хяналт тавьж ажиллана;

Стратеги 6. Хөндлөнгийн мэдээллийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийж, эх үүсвэрийг тогтоох, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилтыг хангуулах үүднээс мэдээлэл солилцох үйл ажиллагааг татварын албаны мэдээллийн технологийн хөгжлийн түвшинд нийцүүлэн шинэчлэн зохион байгуулна;

ЗОРИЛТ 3. Татвар төлөх нийгмийн сэргэлзүйг төлөөшүүлж, татвар төлөгч бүрт хүрсэн татварын цогц үйлчилгээг бүрдүүлнэ:

Стратеги 1. Татварын хууль тогтоомжид заасан татвар төлөгчийг бүртгэх, сургалт сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зэрэг татвар төлөгчдөд үзүүлж буй үйлчилгээг албаны хэмжээнд зохион байгуулж хяналт тавьж ажиллана;

Стратеги 2. Цахим татварын систем “e-tax” болон Татварын цахим төлбөрийн систем “e-payment”-ийг үе шаттайгаар татварын албаны хэмжээнд нэвтрүүлж, татвар төлөгчтэй харилцах нэгдсэн цахим тогтолцоог бий болгоно;

Стратеги 3. Татвар төлөгч болон нийгэмд чиглэсэн орчин үеийн дэвшилтэт технологи, инновацид суурилсан цахим үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ;

Стратеги 4. Татвар төлөгчдөд зориулсан харилцагчийн удирдлагын системийг нэвтрүүлж, татвар төлөгч болон Төрийн бус байгууллагтай хамтран ажиллах харилцааг өргөжүүлнэ. Татвар төлөгчийн сэтгэл ханамжийг үнэлэх санал асуулгын болон бусад үйл ажиллагааг боловсронгуй болгоно;

Стратеги 5. Татвар төлөгчдөд үзүүлэх болон нийгэмд чиглэсэн татварын үйлчилгээнд орчин үеийн шинэлэг арга хэлбэр, агуулга бүхий үйлчилгээний төрлүүдийг шинээр санаачилан нэвтрүүлнэ;

ЗОРИЛТ 4. Татварын албаны хүний нөөцийн болон технологийн чадаевхийг бэхжүүлж, цахим технологи, инноваци, мэдлэгт сууринсан татварын удирдлагыг бэхжүүлнэ:

Стратеги 1. Татварын албаны хэмжээнд хүний нөөцийн удирдлагын нэгдсэн сүлжээтэй болж хүний нөөцийн бодлогыг тодорхойлон, удирдлагын манлайллыг хэрэгжүүлнэ;

Стратеги 2. Татварын албанд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэдлэгийн менежментийг боловсронгуй болгох замаар өндөр мэдлэг, ур чадвар бүхий хүний нөөцийг бий болгоно;

Стратеги 3. Татварын албаны гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтын ажиллагааны бодлогыг татварын албаны хөгжил, албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхэд чиглүүлнэ;

Стратеги 4. Үндэсний татварын албаны хэмжээнд сахилга хариуцлагыг дээшлүүлэн, авилгатай тэмцэх ажлыг эрчимжүүлж, ашиг сонирхлын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлын чиглэлээр тусгай төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана;

Стратеги 5. Татварын удирдлагыг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. Инновацийн үйл ажиллагааг идэвхжүүлж, албан хаагчдын оролцоог нэмэгдүүлнэ;

Стратеги 6. Мэдээллийн технологид сууринсан Үндэсний татварын албаны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог боловсронгуй болгоно;

Стратеги 7. Татварын албанд ашиглагдах мэдээллийн системийн хоорондын архитектурын шийдлийг боловсруулж, “Татварын удирдлагын мэдээллийн систем “trips”-ийг албаны хэмжээнд нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

Стратеги 8. Татварын албаны мэдээллийн системийн дэд бүтцийг сайжруулж, сүлжээний хэвийн ажиллагааг ханган нууцлал, аюулгүй ажиллагааны стандартыг нэвтрүүлж, байнгын хяналт тавьж ажиллана;

Стратеги 9. Татвар төлөлтийг хялбаршуулах бүртгэлийн системийг нэвтрүүлж, бэлэн мөнгөний төлбөр тооцооны бүртгэл, хяналтын үйл ажиллагааг автоматжуулна.

-----oOo-----